

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН БАТАЛСАН УДИРДАМЖИЙН ДАГУУ ГЕРОНТОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙГ АРИЛГАСАН, ЗӨВЛӨМЖИЙГ
ХАНГАЖ АЖИЛЛАСАН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
ЭМЯ-ны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу ГҮТ-ийн зарим үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан, өгсөн 9 зөвлөмжийн хүрээнд 23 ажил төлөвлөж хэрэгжүүлэв.				
Зөвлөмж 1. Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, мэргэжлийн хүний нөөцийн удирдлагыг сайжруулах;				
1	Удирдлагын зөвлөлийн гишүүдийн манлайлал, ур чадвар, харилцаа, хандлагыг сайжруулах сургалтыг тасралтгүй зохион байгуулах	Сургалт хамрагдсан удирдах ажилтны тоо	2025 онд Удирдлагын гишүүдээс 6 ажилтан сургалтад хамрагдсан байна.	-Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй Захирал, Дэд захирал, Хүний нөөцийн менежер, Эдийн засагч зэрэг албан тушаалтнуудын чиг үүрэгтэй холбоотойгоор хууль нийцсэн үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхээр хууль зүйн болон төрийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн салбарт мэргэшсэн мэргэжилтэнг шинээр ажилд авч, эрх зүйн зөрчилгүй шийдвэр гаргуулахгүй байхад анхаарч ажиллаж байна. - Ёс зүйн салбар хороотой хамтран 2025 оны тусгайлсан төлөвлөгөөнд нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд болон удирдах албан тушаалтныг хамруулан сургалт зохион байгуулах, Ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой аливаа, зөрчил гаргуулахгүй байх үүднээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тус тус хамтран ажиллахаар төлөвлөж байна.
2	Мэргэжлийн хүний нөөцийн удирдлагын чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ авах	Зөвлөн туслах үйлчилгээ авсан тайлан	Мэргэжлийн хүний нөөцийн удирдлагын чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ авсан байна.	Мэргэжлийн хүний нөөцийн удирдлагын чиглэлээр Монголын Хүний нөөцийн удирдлагын шинэчлэлийн Академиас зөвлөх үйлчилгээ ажиллахаар төлөвлөсөн. 2025 оны 1-р улирал багтаан зөвлөх үйлчилгээг авч хэрэгжүүлнэ.
Зөвлөмж 2. Төрийн хэмнэлтийн тухай хууль, дагалдаж гарсан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг мөрдөж ажиллах;				
3	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	“Нарлаг хайст” ХХК-д автомашины сэлбэг хэрэгслийн төлбөр 3,500,000 төгрөгийн	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуультай нийцүүлэн аливаа гүйлгээ, бараа материал ажил үйлчилгээтэй , холбоотой аливаа гүйлгээ хийхдээ холбогдох хууль, журмын шаардлага хангасан нотлох баримт бүхий анхан шатны баримтыг үндэслэн гаргаж байх болно.


№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
	хэсэгт заасан “анхан шатны баримт”-ыг бүрдүүлж гүйлгээ хийх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудыг зөрчсөн зөрчлүүдийг арилгаж, цаашид хэрэгжүүлж ажиллах		<p>гүйлгээг санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэх</p> <p>"Гүн Хабсу" ХХК-ийн хооронд байгуулсан 2024 оны 2024/02 дугаартай "Автомашинны гараж түрээслэх гэрээ" хуурамч байж болзошгүй байгаа тул дахин шалгалт хийж төсвийн шууд захирагчид танилцуулах</p>	<p>-Гомдол, мэдээллийн дагуу хууль хяналтын байгууллагад АТГ-т энэхүү асуудал шалгагдаж байгаа.</p> <p>-Энэхүү ажил үйлчилгээ гүйцэтгэх, бараа материал худалдан авах шууд гэрээг байгуулахдаа “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа,ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг мөрдөж алдааг давтан гаргахгүй, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн ажиллана.</p>
4		Зөрчлийг арилгасан арга хэмжээ	<p>"Гүн урлал мөнх" ХХК-ний захирал нар нь шинээр ашиглалтад орох эмнэлгийн барилгын 1 дүгээр давхрын дотор засал, тохижилт хийлгэхээр 2024/09/02 дугаартай, 8,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээг байгуулахаас өмнө ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудаас авсан үнийн санал авах, зах зээлийн ханшнаас өндөр үнэтэй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу</p>	<p>-Гэрээний хэрэгжих хугацаа дууссан.</p> <p>-Байгуулагаас төлбөр шилжүүлээгүй.</p> <p>-Цаашид энэхүү зөрчилтэй холбоотойгоор бараа материал, ажил үйлчилгээ гүйцэтгэх, худалдан авах шууд гэрээг байгуулахдаа “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа,ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг мөрдөж алдааг давтан гаргахгүй ажиллана.</p>

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
			шийдвэрлэх	
5		Зөрчлийг арилгасан арга хэмжээ	"Космос тек Монгол" ХХК-аас нийлүүлсэн 51,000,000 төгрөгийн үнэ бүхий цахилгаанаар өвдөлт намдаагчийн үнэний талаар холбогдох тайлбарыг авах	-Гомдол, мэдээллийн дагуу энэхүү худалдан авахтай ажиллагаатай холбоотой "Космос тек Монгол" ХХК-аас нийлүүлсэн 51,000,000 төгрөгийн үнэ бүхий цахилгаанаар өвдөлт намдаагч тоног төхөөрөмж нийлүүлсэн хуулийн этгээд, захиалагч талын ГҮТ-ийн үнэлгээний хороо, захирал нарыг хянан, шалгаж байгаа. -Эрүүгийн эдийн засгийн цагдаагийн алба тухайн багажны үнийн талаар санхүүгийн шинжээч томилогдон судлаж байна.
6	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар тесвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглосон байна.	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	Монгол улсын засгийн газрын 2019 оны 01сарын 09 ний өдрийн 6 тоот тогтоол "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам" Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах Авто машины гаражийн түрээсийн үний судалгааг хийж гэрээ байгуулан төвийн 3 автомашинуудыг журмын дагуу дулаан зогсоолд байршуулж, өвөлжилтийн бэлэн байдал, үйл ажиллагааны тасралтгүй	-Байгууллагын тээврийн хэрэгслийг албан хэрэгцээнд хот дотор хэрэглэж байгаа хувийн зорилгоор ашиглаагүй, албаны хэрэгцээнд ашиглаж байсан болно. -Байгууллагын албан хэрэгцээний 3 тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын хөрөнгө төсөвт тусгагдаагүй тул гражийн түрээсийн асуудал яригдах боломжгүй. 3 тээврийн хэрэгсэл төвийн хашаанд харуул хамгаалалт, камер бүхий газар байршуулж байна. -Байгууллага нь тээврийн хэрэгслийг цаашид зориулалтын байранд хадгалах арга хэмжээ авна.



№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
			байдлыг хангах	
Зөвлөмж 3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж ашиглах;				
7	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т заасан заалтыг хангаж ажиллах	Эд хөрөнгийн хүлээж авсан тайлан	ГҮТ-ийн хөрөнгө болох эмнэлгийн зориулалттай 44 ширхэг орыг агуулахын эзэн гэх иргэн Манлай- Эрдэнэтэйтэй байгуулсан гэрээг дүгнэж агуулахын түрээсийн үнийн судалгаа хийж шалгарсан байгуулагатай гэрээ байгуулан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, эд хариуцагч хүлээж авах.	-Эмнэлгийн зориулалттай 40 /2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн болон авсан 2 талын комиссын актанд 40 ороор тусгагдсан/. Эмнэлгийн зориулалттай өвчтөний 40 ширхэг иж бүрэн орыг хариуцагч талаас хүлээлгэн өгөх үед ГҮТ хадгалах хамгаалах агуулах нөөцийн боломж байхгүй, гадны нөлөө эрсдэлээс хамгаалах үүднээс иргэн Манлай-Эрдэнэтэй гэрээ байгуулж хадгалуулсан. -Эдгээр эмнэлгийн зориулалттай иж бүрдэл 40 орыг хүлээн авах ГҮТ-ийн Захирлын 2025 оны 1 дүгээр сарын 17-ны А/03 тушаалаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж байна. Гэвч эдгээр иж бүрдэл 40 орыг хүлээн авч хадгалах агуулах түрээслэх төсөв, нөөцийн боломжгүй, 2025 оны төсөвт контейнер худалдан авч байрлуулах зохион байгуулалтын арга хэмжээ авна.
8	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/414 дүгээр тушаалаар баталсан "Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам"-д зааснаар хороо нь эмийн сонголт, түгээлт хадгалалт, хэрэглээ, хүртээмжид хяналт тавихзорилготой. Мөн журмын 3.1.9 заалтыг хэрэгжүүлж ажиллах	Хяналт үнэлгээ хийсэн тайлан	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/414 дүгээр тушаалаар баталсан "Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны хяналт-үнэлгээг хийж төвийн удирдлагын зөвлөлд танилцуулах	-Геронтологийн үндэсний төв нь төвийн захирлын 2022 оны А/62 дугаар тушаалаар "Эмийн эмчилгээг зохицуулах хороо"-г 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. -Эмийн эмчилгээний хороо нь төвөөс ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний үе дэх яаралтай тусламж, гамшгийн үеийн болон зайлшгүй шаардлагатай эмийн сонголт, нөөц бүрдүүлэлт, нийлүүлэлт, хадгалалт, зарцуулалт түгээлтийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилладаг. -Төвөөс үзүүлж буй тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмийн нөөцийн сонголт, нийлүүлэлт, хадгалалт, зарцуулалтын тайлан, дүгнэлтийг удирдлагын багийн хурлаар хэлэлцэж, эмийн чанар, хангамж, хэрэглээтэй холбоотой асуудлыг эмийн эмчилгээний хорооны саналыг үндэслэн шийдвэрлэдэг. -Эмийн эмчилгээний хороо нь тухайн жилд Эм ханган нийлүүлэх байгууллагаас нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ оношилгоонд хэрэглэж буй шинэ эмийн мэдээллээр эмч, эмнэлгийн

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
				<p>мэргэжилтнүүдэд 2 удаагийн сургалт, мэдээлэл зохион байгуулсан.</p> <p>-Эмийн зохицуулах хороо нь эмийн сонголт хийхэд стратеги төлөвлөлтийн албатай хамтран ажиллаж, эм ханган нийлүүлэх байгууллагуудад үнийн саналыг илгээж, ахмад настанд чанартай эмээр үйлчлэх бодлогыг баримталж ажилладаг.</p> <p>-Эм ханган нийлүүлэх байгууллагаас ирсэн саналаас сонголт хийж төвийн эмийн нөөцийг бүрдүүлдэг.</p> <p>-Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанаас 2024 онд 4 удаа эмийн хадгалалт, эмийн чанарт хяналт үнэлгээг тодорхой хуваарийн дагуу явуулж, дүгнэлт, зөвлөмж өгч хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>-Төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний дагуу өдрийн эмчилгээ, яаралтай тусламж шаардлагатай ахмад настнуудад эмийн эмчилгээ хийж байна.</p>
<p>Зөвлөмж 4. Байгууллагын ажилтнуудын харилцаа хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөх хууль тогтоомжийг судлуулан, мөрдөж, ажиллах;</p>				
9	Ажилтнуудын харилцаа хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөх хууль тогтоомжийг судлуулан, мөрдөж, ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тайлан	2025 онд төлөвлөгөө гаргаж, 2025 оны 01 дүгээр сард 1-2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна.	-ГҮТ-ийн эмч, мэргэжилтнүүдийн харилцаа хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Эмч мэргэжилтний ёс зүй, эмч эмнэлгийн ажилтны харилцаа, эмч үйлчлүүлэгчийн харилцаа, хандлага, хэм хэмжээ сэдвээр 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр АШУҮИС-ийн БАС-ийн Харилцааны ур чадварын тэнхим тэнхимийн багш, АУ-ны доктор, дэд профессор О.Болорсайханыг урьж сургалт явууллаа. Сургалтад Геронтологийн үндэсний төвийн удирдах бүрэлдэхүүн, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд 28 хүн идэвхтэй хамрагдсан.

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
				 <p data-bbox="1144 884 2125 1050">-Ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөх ёс зүйн хэм хэмжээ, харилцаа, хандлага, <u>хууль тогтоомжийн талаар</u> 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр ЭМЯ-ны ёс зүйн хорооны экс гишүүн С.Гантуяа сургалт явуулсан. Тус сургалтад ГҮТ-ийн нийт эмч ажилтан ажилтад 25 хүн хамрагдсан.</p>

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
				
Зөвлөмж 5. Албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангах, хөдөлмөрийн харилцаанд дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход онцгой анхаарч албан хаагчдын тогтвор суурьшлыг хангах;				
10	Хүний нөөцийн сэтгэл ханамжийн судалгааг хийж, дүгнэлт зөвлөмжийг удирдлагын зөвлөлд танилцуулах	Судалгааны тайлан	2024 онд сэтгэл ханамжийн судалгааны тайлан удирдлагын зөвлөлд танилцуулга хийж, арга хэмжээ төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн байна.	<p>-Геронтологийн үндэсний төвийн эмч, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг Google Form ашиглан цахимаар болон цаасаар Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 дугаар тушаалд заасны дагуу 2024 онд 2 удаа авсан. Судалгаанд нийт 42 ажилтан буюу 93 хувь хамрагдсан.</p> <p>-Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаагаар байгууллагын соёл, ажлын орчин, ажилтанд үзүүлж байгаа нийгмийн баталгаа, сургалт, дэмжлэг, хамт олон, ажилтнуудын харьцаа, хандлагыг хамруулсан асуулгыг оруулсан.</p> <p>-Судалгааны тайлан, дүгнэлтийг төвийн удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж, ажилтнуудаас дэвшүүлсэн саналын дагуу 6 ажил төлөвлөж, 90 хувьтай хэрэгжүүлсэн.</p> <p>-Ажилтнуудаас дэвшүүлсэн саналыг нэгтгэн дүгнэхэд ажлын байрны аюулгүй орчин, ажлын байрны стандарт мөрдөлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, халдвар хамгааллын үнэлгээ өмнөх оны түвшинд байна.</p> <p>-Энэхүү судалгааны дагуу цаашид ажилтнуудын ажиллах орчин</p>

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
				нөхцөлийг сайжруулах чиглэлээр тусгайлсан төлөвлөгөө гарган ажиллахаар төлөвлөж байна.
11	Ажлын байрны Сүүлийн 3 жилийн шилжилт хөдөлгөөний шалтгааныг нарийвчлан судалгаа хийж, удирдлагын зөвлөлд танилцуулах	Тайлан мэдээ	Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний тайланг сүүлийн 3 жилээр дэлгэрэнгүй гаргаж санал зөвлөмж боловсруулсан байна. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний судалгааг тухай бүрд нь авч хэвшүүлсэн байна.	<p>2022 онд ажлаас чөлөөлөгдсөн 14 ажилтнаас 1 ажилтан тэтгэвэр тогтоолгосон, 3 ажилтан сурахаар ажлаас чөлөөлөгдсөн байна.</p> <p>2023 онд ажлаас чөлөөлөгдсөн 25 ажилтнаас 3 ажилтан тэтгэвэр тогтоолсон, 3 ажилтан хүүхэд харах чөлөөтэй байсан. 4 ажилтан түр болон туршилтын гэрээгээр ажиллаж байсан, 3 ажилтантай ажил олгогчийн санаачлагаар ажлаас чөлөөлсөн байна.</p> <p>2024 онд ажлаас чөлөөлөгдсөн 17 ажилтнаас гэрээгээр буюу бүрэн бус цагаар ажиллаж байсан 4 буюу 27 хувь, гадаад улс болон орон нутаг руу шилжин ажиллаж буй 4 буюу 27 хувь, Түр болон туршилтын хугацаагаар ажиллаж байсан 2, тэтгэвэр тогтоолгосон 2, цалин хөлс бага гэсэн шалтгаанаар чөлөөлөгдсөн 3 ажилтан байна.</p> <p>2023-2024 онд хүний нөөцийн тогтвортой ажиллах гэрээг 3 ажилтантай хийж, нийгмийн баталгааг дэмжих зорилгоор 100 орчим сая төгрөгийг ажилтнуудад урамшуулал болгон олгосон байна.</p> <p>Нийт ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд ажлаас гарсан шалтгаан:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ажлын байрны нөхцөл 2. Цалин урамшуулал бага 3. Удирдах ажилтан болон хамт олны уур амьсгалаас шалтгаалж ажлаас чөлөөлөгдөж байна. <p>Цаашид ажлаас гарсан, чөлөөлөгдсөн ажилтнуудаас шалтгаан, нөхцөлийн талаар судлах арга хэмжээ авч, шинэ эмнэлгийн барилгын ашиглалтад оруулах, цалин урамшууллыг нэмэгдүүлэх, ажилтнуудад ёс зүй, харилцаа хандлагын төлөвшүүлэх сургалт тогтмол орохоор төлөвлөж байна.</p>
12	Хөлсөөр ажлуулах гэрээг үндсэн орон тоон дээр байгуулж ажлуулсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах	-Зөвлөмжийг хүлээн авч, 2025 оноос хөлсөөр ажлуулах гэрээгээр 2024 онд 5 /Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, Халдвар судлаач, Хуулийн мэргэжилтэн, Жолооч, Настны сургалт хариуцсан мэргэжилтэн, Нүдний эмч/ ажилтантай байгуулж ажлуулсныг 2025 оны 01 сараас Халдвар судлаач, Нийгмийн эрүүл мэндийн ажилтныг бүтэн орон тоогоор, Хуулийн мэргэжилтэн, Нүдний эмчийн хөлсөөр ажиллуулах гэрээг дуусгавар болгож дахин хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж


№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
				байна.
13	Хөдөлмөрийн гэрээг томилогдох тушаал гарахаас өмнө байгуулсан зөрчил гарсан байна.	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах	-Шинээр ажилд авсан Хуулийн мэргэжилтний зөвлөгөө болон ЭМЯ-наас өгсөн зөвлөмжийн дагуу ажил олгогчийн зөвшөөрөл, төвийн захирлын тушаал гарах үед буюу гарч, баталгаажуулан, тушаалаар өгсөн үүрэг даалгаврын дагуу Хүний нөөцийн менежер ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахаар тушаалд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. -Мөн шинээр боловсруулж буй хөдөлмөрийн дотоод журамд энэхүү асуудлыг тусгайлан зохицуулахаар тусгаж өгсөн болно.
14	Хөлсөөр ажиллах гэрээнд сар бүр ажилласан хугацааны тайланг бичихээр заасан ч ажилчдын гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээт ажилтны тайланг хавсаргаагүй, зөвхөн тойрох хуудсаар ажлыг хүлээлцсэн зөрчлийг арилгах	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах	-Хөлсөөр ажиллуулах гэрээг 2025 оны 01 сараас өөрчилж хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилтан нь сар бүр тайланг бичиж тухайн харъялагдах албаны даргад тайлагнаж тайланг төвийн дундын санд байршуулж байна. -Зөвлөмжийн дагуу цаашид ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллуулж буй этгээдээс тайланг заавал авах, дүгнэх ажлыг тогтмолжуулан ажиллах болно.
15	Хүний нөөцийн томилгооны тушаалын талаар гарсан зөрчлүүдийг арилгах	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах	-Ажил олгогчийн зөвшөөрөл, төвийн захирлын тушаал гарах үед буюу гарч, баталгаажуулан, тушаалаар өгсөн үүрэг даалгаврын дагуу Хүний нөөцийн менежер ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахаар тушаалд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.
16	Төвийн захирлын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/64 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах	-Төвийн “Шинэ ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 6.1 дахь заалтын дагуу сонгон шалгаруулалтын явцыг ГҮТ-ийн сонгон шалгаруулалтын бүртгэл, ярилцлагын үнэлгээний хуудасыг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. -Цаашид олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хаягт хүний нөөцийг бүрдүүлэх ажил болох сул орон тоог нөхөхдөө нийтэд ил тод, нээлттэй байдлаар зарлан, дээрх журмыг


№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
	ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын хэрэгжилтийг хангах.			баримтлах болно.
17	Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Боловсруулсан төлөвлөгөө	Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.	-Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулж төвийн захирлаар баталуулж үйл ажилгаандаа хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөөд байна. -Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын төсөлд Эрүүл мэндийн тухай хуультай нийцүүлэн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудлыг тусгасан болно.
Зөвлөмж 6. Хөдөлмөрийн дотоод журмыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн шинэчилж, нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулах				
18	Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах	Боловсруулан батлуулсан журам	Хөдөлмөрийн дотоод журмыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн шинэчилж, нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулсан байна.	Төвийн захирлын 2025 оны А/04 дугаар тушаалаар хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж, төвийн тасаг, нэгж, ажилтнуудаас саналыг авч боловсруулж байна. Төвийн хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах ажлыг хэсэг гаргаж, боловсруулан, нийт ажилтнуудаас санал авч, 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс өмнө Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар төлөвлөж байна.
19	Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжилтийн үнэлгээний тайлан	Хөдөлмөрийн дотоод журмын 3.3, 5.3, 9.17.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж, илтгэх хуудсаар төвийн захирал болон удирдлагын зөвлөлд танилцуулсан байна.	Төвийн ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар боловсруулж батлуулахаар ажиллаж байна. Хөдөлмөрийн дотоод журмын 5.3 дахь заалтын дагуу 2025 оны 01 сард төвийн ажилтан бүр ажлаа жилээр төлөвлөж, төлөвлөгөөгөө албаны даргаар баталгаажуулан ажиллаж байна.

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
				 <p>9.17.6 дахь заалт Хөдөлмөрийн тухай хуулийн 64.5 дахь заалтыг зөрчсөн зөрчлийг арилгаж төвийн хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилэн боловсруулсан.</p>

Зөвлөмж 7. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн шинэчлэх;

20	Ажлын байрны дутуу байгаа албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулж батлуулаалах	Боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын тоо	6 орон тооны албан тушаалын тодорхойлолт боловсруулж батлуулсан байна.	Ажлын байрны дутуу байсан албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулж батлуулсан./Халдвар судлаач, Эрүүл мэндийн статистикийн мэргэжилтэн, Хуулийн мэргэжилтэн, Хяналт үнэлгээ дотоод аудитын мэргэжилтэн, Настны сургалт хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн нийгмийн ажилтан/
----	---	---	--	---

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
				
21	Бүх ажилчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах	Боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын тоо	52 орон тооны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан байна.	Төвийн нийт ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн шинэчилэн боловсруулж байна. 70 хувь
Зөвлөмж 8. Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах				
22	Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартыг зөрчсөн эсэхэд үнэлгээ хийж, холбогдох ажилтнуудыг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	<p>Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам “ ийн 4 дэх “тамга тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах” 4.1.4 заалт албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд бичиг хэргийн ажилтан тэмдэгтийг хэрэглэх заалтын дагуу байгууллагад баримт бичиг хүлээн авсан тухай тэмдгийг дардсыг хийлгэн авсан . АХХ хуулийн 44-р зүйл, 44.3 дах заалтын дагуу: Байгууллагын “Хөтлөх хэргийн жагсаалт” боловсруулан, ХХНЖ–ыг индексийг батлуулах, харьяа байгууллага эрүүл мэндийн яамны архивд хянуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажилласан. Байгууллагын архивын үйл ажиллагаанд:</p> <p>АХХ хуулийн 46-р зүйл 46.5 дах заалтыг дагуу: Баримт бичгийг ангилан төрөлжүүлэн албан хэрэг бүрдүүлэх, цахим хэлбэрт шилжүүлсэн баримтаа тусад нь компьютерт нь цахим сан үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хавтас файл үүсгэн хадгалах, тэдгээрийг архивт шилжүүлэхэд бэлтгэл ажлыг хангаж</p>

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
				ажиллахаар 2025 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Мөн байгууллагын он онд хийсэн ажлын түүхийг бичиж түүхчилсэн файл үүсгэсэн. Архивын баримтын бүртгэлийг тулгалт хийж БНШК ын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан
Зөвлөмж 9. Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй, шударга, ёс зүйтэй байдлыг хангах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг шуурхай арилгах, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх				
23	Төвийн цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал-Нээлттэй ажлын байр” цонхонд сул орон тооны мэдээллийг үйл ажиллагааг сайжруулах, тасралтгүй байдлыг хангах	Зөрчлийг арилгасан арга хэмжээ	Хүний нөөцийн ил тод байдал-Нээлттэй ажлын байр” цонхонд сул орон тооны байршуулж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажилласан байна.	<p>Геронтологийн үндэсний төв нь 52 бүтэц, орон тоотой батлагдсан. Үүнээс 47 нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажиллаж байна. Сул орон тоо-5 /Стратеги төлөвлөлтийн албаны дарга, Эрүүл мэндийн статистикийн мэргэжилтэн, Хяналт үнэлгээ дотоод аудитын мэргэжилтэн, Олон мэргэжлийн багийн эмч, Жолооч/ Төвийн цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал- Нээлттэй ажлын байр” цонх болон “Геронтологи хүний нөөц facebook-т байршуулсан.</p> 
24	Ажилтнуудын хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Гарсан шийдвэрүүдийн тоо	Зөвлөмжийн дагуу холбогдох ажилтнуудыг удирдлагын зөвлөлийн хурлаар болон хамт олны хурлаар хэлэлцүүлж	-Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс зөрчил гаргасан асуудал, цаашид сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан зохицуулалт хийж, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулахаар төлөвлөж байна.

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
			хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	